

сайн барилдлагад эвлүүлэн ламын зарлиг ёсоор бүтээлийн үүлэн далайд зорьж Эрдэнэ зуугийн нэрийг хадгалагч гавж Гончогжалцан бээр 15 жарны доторхи мич хэмээх гал эм хонин жилийн монгол 2 дугаар сарын шинийн 15-ы өдөр өөрөө бүтсэн их амгалан эрдэнэ зуугийн хийдийн ойр орчим найруулав. Бичээчийг гэлэн Цэпэлдорж бээр үйлдсэн болой. Үүгээр ч шашин баригч төрөлхтөн дээд нүүгүүдийн өлмийн лянхуа батжин зохиол үйлс зүг, цаг бүхнээ дэлгэрэх шалтгаан болтугай.

Энэхүү төгсгөлийн үгээс үзвэл Гончогжалцан ламтан бээр “бэрх нэрт Буньяшвара”-гийн “зарлиг соёрхсоныг бишрэн аваад лам дээд тэр ямагтын дэргэдээс ядамжамцын дүгтавринчэнжүннай-гийн даган соёрхлыг сонссон” зэргээс үзвэл Буньяшвара бол Гончогжалцан ламтны бишрэн шүтэж хүндэлж явсан мэргэдийн нэг болох нь харагдаж байна. Ямар ч байсан энэ нэр бол Гончогжалцангийн нэрийн өөр нэг хувилбар биш болох нь тодорхой байна. Энэ судруудын төгсгөлд *Буньяшвара гавж цорж* хэмээн нэр дурдагдсан хүн бол Гончогжалцан ламтныг ном бичихийг дуртгасан нэгэн бололтой гэж таамаглаж байна.

Аливаа судрын төгсгөлийн үгд тухайн зохиогчийн намтар бүтээлтэй холбогдох мэдээ цөөнгүй орсон байдаг тул Гончогжалцан ламтаны сүмбүмд орсон зохиолууд дахи төгсгөлийн үгд тэмдэглэсэн гол гол мэдээг нэгтгэн авч үзье. Үүнд:

Нэрээ бичсэн тухайд

Нэрээ шууд бичихээс гадна уламжлал ёсоор санскритаар сэргээж бичжээ. Тухайлбал: *Раднадуваза* гэсэн нь Гончогжалцаны нэрийн санскрит хөрвүүлэг болно. Түүнчлэн Эрдэнэ зуугийн ламын нэр зүүсэн (өөрийгөө доорд үзсэн байдлаар бичсэн), гавж аграмба Гончогжалцан, Эрдэнэ зуугийн ламын нэр зүүсэн гавж Гончогжалцан, Эрдэнэ зуугийн лам хэмээн алдаршсан тойн Гончогжалцан, Эрдэнэ зуугийн ламын нэр зүүсэн ерийн хүмүүн Гончогжалцан, Эрдэнэ зуугийн лам хэмээн алдаршсан гавж Гончогжалцан, шавь Раднадуваза, Их Хүрээний нэр зүүсэн хоёрдугаар төгөлдөр Раднадуваза гэх зэргээр бичжээ.

Цол зэргийн тухайд

Гончогжалцан ламтан өөрийгөө гавж, аграмба цолтой гэж бичжээ.

Бичээчийн тухайд

“Шинжлэл төгөлдөр” гэлэн Соднамдорж, “санваарт хичээнгүй тийн шинжлэл төгс” гэлэн Базар, гэлэн Цэпэлдорж нар Гончогжалцан ламтны зохиолыг бичиж тэмдэглэжээ. Ингэхдээ хамгийн олонтоо нэр дурдагдсан хүн бол гэлэн Соднамдорж болно.

Хаана бүтээсэн тухайд

Төвдөөр Гэсоглин, монголоор орчуулбал Буян хурах хийд хэмээн алдаршсан хийдэд найруулжээ. Түүнчлэн Орхон голын хөвөөнөө найруулав, умар зүгийн шашны үзэсгэлэнт чимэг орон хийд Гэсоглинд найруулав гэж бичжээ.

Ямар хүмүүсийн дуртгаснаар бүтээсэн тухайд

“Шашны их өглөгийн эзэн туслагч эрх ноён Ригзиндорж” (*Догшин сахуус Жамсринд балин*

өргөх ёс), “алдрыг өгүүлэхүй бэрх ачит лам Доржчан цорж ринбүчи болон шавь нар дурсанд бүтээсэн” (*Өөрөө гарсан гэгээн сахиусны хүрд*), “гавж Лодой өөрийн сүсгийн шүтээнд дээд тэнгэр энэ ямагтын шүтээнийг босгосон түүнээ магтаал нэгэн хэрэгтэй хэмээн дурдсанд” (*Хутагт Жанрайсийгийн магтаал*), “найман их аюулаас гэтэлгэх Дара эхийн шүтээнийг босгох цагт сүсэг төгс шавь нэгэн бээр шүтээн түүнээ уншлага залбирал ерөөл хэрэгтэй хэмээн шамдсанд” (*Гэтэлгэгч Дара эхийн залбирал*), “сүсэг хичээнгүй тийн шинжлэл аугаа гэлэн Содов бээр дахин дахин дурдсанд” (*Чадагчийн эрхтийн хуврагийг арвижуулах магтаал*), “олон эрдмийн сан барьсан ловон Шаравдондүвсамбуу нэр дурдсанд шүтэж” (*Бат агч ламын соёрхсон шүлэг*) гэх мэт эгэл шавь сурагчаас эхлээд эзэд ноёд, лам хувраг нарын хүсэлтээр бичсэн нь тодорхой байна.

Хэдэн онд бичсэн тухайд

Эрлэг номун хааны нууц бүтээлд шүтээж, хишиг дуудах ёс сансар нирвааны цог учралыг дуудах сан хөмрөг хэмээсэн үүнийг ч дээд лүгээ зохилдуулан 15 дугаар жарны тоологдохуун гучин зургаа баясгалан үйлдэгч хэмээх усан эр барс жилийн намрын дунд сарын 15-ы өдөр (1902 он), Өөр оорийн үндэс ламд барилдлагатай болох шавдан өргөх ёсны их амгалангийн цэнгэлийн баяр хурим хэмээх оршив хэмээхийг 15 жарны доторхи мич хэмээх гал эм хонин жилийн монгол 2 дугаар сарын шинийн 15-ы өдөр (1907 он), Ламын ёог лугаа барилдуулж, насны тийн гурван бурханыг шүтсэн өөр бусдын насыг арвижуулах хийгээд үрэл бүтээх үйлийн ёс үхэл үгүйн сайн хумх хэмээх зохиолоо модон могой жилд (1905 он), Их тэнгэр Бурнаабадраагийн хумхны бүтээл эдийн сан хөмрөг зохиолоо 15 жарны модон барс жил (1914 он) бүтээсэн хэмээн тэмдэглэжээ.

Ямар зорилгоор бүтээсэн тухайд

Мажигдодхамванчүгбалданлхамын балингийн зан үйл үйлсийн тийн дөрвөн зүйл аяндаа бүтэх хэмээх үүнийг “Эрдэнэ зуугийн энэхүү хийдийн шашны хамаг үйл хийгээд ялангуяа хуврагийн аймгийн харшлах нөхцөл бүгдийг арилгаж, зохилдох нөхцөл бүгдийг бүтээх аливаа аргад шүтвээс сайтар шинжлэн номыг тэтгэх сахиус энэ ямагтад балингийн үйл энэ мэт нэгэн хэрэгтэй” хэмээн Эрдэнэ зуу хийдийн шашин номын үйл хэргийг сайжруулах зорилгоор бичсэн ажээ.

Ерөөлийн үг бичсэн тухайд

Эрдэнэ зуугийн ламтан Гончогжалцан зохиолынхоо төгсгөлд олон сайхан ерөөлийн үгийг бичжээ. Тухайлбал

“үүгээр ч зөөлөн итгэл ялгуусан хоёрдугаарын шашин эрдэнэ энэ ямагт олз хүндлэл лүгээ сэлт дэлгэрч арвижин орших болтугай”

“Ялгуусны шашны лянхуа мишээх аугаа цэцэрлэгт

Саруул оюутны дунд тоолишгүй зургаан хөлт зөгийг цэнгүүлэхийн тулд

Орон хийд Буян хураах дээд хийдийн тэнгэрийн морөөс

Барагдах үгүй рашааны хур буух болтугай”,

“Сайн буян арвижих болтугай”,

“энэ үйлээр ч ялгуусны шашин эрдэнэ олз хүндлэл лүгээ сэлт дэлгэрч арвижин өнөд орших болтугай”,

“үүгээр ч шашин баригч төрөлхтөн дээд нүүгүүдийн өлмийн лянхуа батэжин зохиол

үйлс зүг, цаг бүхнээ дэлгэрэх шалтгаан болтугай”,

“Үүнээ хичээсний хүчээр амьтны сэтгэлийн огторгуйг бүрхэх үйлийн нисваанисын үүлийг

Эш онолын номын хийгээр арилгаж, тэвчил онолын огторгуйн чандмани эрдэнэ

Урган гарах лугаа хамт шашин амьтны тус амгалангийн лянхуан цэцэрлэг сайтар мишээж

Шашныг баригч зургаан хөлт зогийн чуулган номлол бүтээлийн бүжгээр сайтар цэнгэх болтугай” гэх мэт бичжээ.

Миний олж үзсэн хоёр боть судар бол эрдэнэ зуугийн ламтаны бүрэн зохиол бус зарим зохиолын эмхтгэл бололтой. Зохиолуудыг бүртгэж үзвэл бичмэл, дармалаар бичсэн нийт 50 гаруй зохиол байна. Зарим зохиолын нүүрэн хуудсанд ботийн дугаарыг тавьсан байна.

Үүнд ᠑, ᠒ зэрэг ботийн дугаар тавьснаас үзвэл энэ ламтаны зохиол цөөн бус боть байсан бололтой. Зарим зохиол тав хүртэл хувьтай байгаа нь олны дунд бичмэл дармалаар тархсан болохыг харуулж байна. Тус сүмбүмд бас өөр бусад зохиогчийн зохиол ч хавчуулагдаж оржээ. Цаашид бусад зохиолыг олж, иж бүрэн болговол зүйтэй.

Зохиолын төгсгөлийн үгэнд бичсэн мэдээг дүгнэвэл ламтан Гончогжалцан бээр номч лам Ишцүлтимпунцогсамбуу гэгээний хойт төрөл байсан байна. Зохиогч нэрээ Гончогжалцан хэмээн бичихээс гадна хуучны бичгийн мэргэдийн нэгэн адил санскритаар хөрвүүлж Раднадуваза хэмээн бичсэн нь зонхилж байна. Зохиолоо ихэнхдээ Эрдэнэ зуугийн орчим орших Гэсоглин хийдэд бүтээжээ. Хийдийнхээ нэрийг төвд үсгээр монгол хэлээр Эрдэнэ зуу хэмээн бичихээс гадна *རྩེ་ཆེན་པོ་* гэж төвдөөр хөрвүүлэн бичжээ. Зохиолоо 1902-1917 оны хооронд шашин амьтны тусын тулд эгэл шавь нараас эхлээд ихэс ноёд, хатад, лам хувраг нарын хүсэлт гуйлтаар бүтээжээ. Ерөөлийн үгийг уран яруу бичсэнээс нь үзвэл зохист аялгууч хүн байжээ.